

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1	“Алсын хараа 2050” бодлогын баримт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.1.1	Хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, нялхасын болон 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах.	Улсын төсөв	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-2.1	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-1.9	2024 оны хүүхдийн эндэгдлийн байдалд судалгаа, дүгнэлт хийхэд нийт эндэгдлийн 50 хувь сэргийлэх боломжтой эндэгдэл тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнтэй уялдуулан бага насны хүүхдийг ахуйн осол гэмтлээс сэргийлэх, хахалтаас сэргийлэх нь, түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж сэдвүүдээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж 191 хүнийг хамруулсан. Бага насны хүүхэдтэй эцэг, эх арсан хамгаалагчдад зориулсан “Нярай хүүхдийн асаргаа”, “Нялх балчир хүүхдийн хооллолт”, “Амьсгалын замын цочмог халварууд”, “Бага насны хүүхдийн суулгалт өвчнөөс сэргийлье”, “Бага насны хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд”, “Бага насны хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх” гэсэн 5 бүлэг сэдэв асуулсан гарын авлага, номыг олшруулж 295 эцэг, эх асран хамгаалагчдад сургалт зохион байгуулж 419 гарын авлага материал түгээсэн. ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас “Нярайн амьсгал гачаал хам шинж”, “Дутуу нярайн халдвар”, “Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати”, “Хүүхдийг осол гэмтлээс	90

						сэргийлье” сэдэвт сургалтыг цахимаар 5 удаа зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын 54 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын хүүхэд болон нярайд тусламж үйлчилгээ үзүүлдэг 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг “Дутуу нярай, хүүхдийн нүдний угийн улаан рефлекс, хараа шалгах” танхимын сургалтанд хамруулсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн шинэ залуу 2 эх баригчийг ажлын байрны дадлага сургалтанд хамруулсан. Анхан шатны 8 эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөн туслахаар ажиллаж 3 удаагийн хугацаат зөвлөмжийг хүргүүлсэн. 2025 оны эхний 5 сарын статистик мэдээгээр 1-5 насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 хүүхдэд 0.7 байгаа зорилтот түвшнээс буурсан үзүүлэлттэй байна.	
1.2	МУ-ын таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.2.1	Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог тусгай хуваарийн дагуу хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан хэлбэрээр зохион байгуулж, хамралтыг нэмэгдүүлэх.	ОНТ, 10 сая	Илрүүлэг үзлэгийн хамралтын хувь.	Илрүүлэг үзлэгийн хамралтын хувь- 43.2	Илрүүлэг үзлэгийн хамралтын хувь - 47.5	Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт НЭ-ийн дэмжих төвөөр 867 иргэн, явуулын баг буюу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд 1904 иргэн, нийт 2807 иргэнийг хамруулсан. Өссөн дүнгээр эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих иргэдийн 47,4%-ийг хамруулж, өмнөх оныхоос 4.2%-иар өссөн байна. Сумдын ЭМТ-үүд элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 2100 иргэнийг хамруулан, В вирус илрээгүй 2011 иргэнийг В гепатитийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын 1, 2, 3-р тунд	100

						хамруулжээ. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/04 дугаар тушаал, ЭМС, БС-ын хамтарсан 2024 оны А/415, А/151 дугаар тушаалаар ЕБС-ын 6 настнуудыг нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/262 тоот тушаалаар үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг батлуулан аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 1057 хүүхдийг эрт илрүүлэг үзлэгт шуурхай хамруулах ажлыг гүйцэтгэж байна. 2025 оны 05 сарын 28-ны өдрийн байдлаар нүдний эрт илрүүлгийн сургуульд суурилсан анхан шатны үзлэгт 100% хамрагдаж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг эхэлсэн. Шүдний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны хүүхдүүдийн 72%-ийг, зүрхний үзлэгт 61%-ийг хамруулаад байна.	
1.3	МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.3.1	“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг эрчимжүүлэх	*	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-95	Элэг бүтэн арга хэмжээг эрчимжүүлэн, эрт илрүүлэг үзлэгт нийт хамрагдвал зохих иргэдийн 8 хувийг буюу 2100 иргэнийг гепатитын В, С вирус илрүүлэх оношилгоонд хамруулж гепатитын С вирусийн архаг халдварын шинэ 6 тохиолдол, В вирусийн архаг халдварын шинэ 5 тохиолдлыг илрүүлж, вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээнд хамруулж 9 иргэнийг эмчилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд Д вирусын халдвартай иргэдийн судалгааг гаргаж, ХӨСҮТ-д хүргүүлсэн.	90

						ЭМГ-ын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар “Хавдрын эсрэг хамтдаа” 6 сарын аяныг аймгийн хэмжээнд зарлан, 31 заалт бүхий төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг боловсруулан ЭМБ-дад хүргүүлсэн. В вирусын сайн дурын дархлаажуулалтыг эрчимжүүлэн нийт 2011 иргэнийг дархлаажуулсан. Мөн Хорт хавдрыг бууруулахад таны миний оролцоо сэдэвт сургалтыг 6 байгууллагын 124 ажилтанд зохион байгуулсан. Эрүүл мэндийн газрын дарга, сумдын засаг дарга, Эрүүл мэндийн төвийн даргын гуравласан гэрээнд хүн амыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх илрүүлэг, үзлэг, сургалт нөлөөлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах талаар тусган хамтран ажиллаж байна.	
1.3.2	Иргэдэд тэнцвэртэй хооллолт, хоол хүнсний зөв хэрэглээг таниулах мэдээлэл сургалт, сурталчилгааны нөлөөллийн ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Сургалтын тоо-Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо-Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо-	• Сургалтын тоо - 10 • Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо - 2400 • Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо 48	• Сургалтын тоо-14 • Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо-2700 • Цахим орчинд байршуулах мэдээллийн тоо 52	“Тэнцвэртэй хооллолт”, “Эрүүл бус хүнсний хэрэглээ” сургалтыг 22 удаа зохион байгуулж, боловсролын 5 байгууллагын 187, Цагдаагийн газрын 30 албан хаагч, 16 сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн 222 иргэнд зохион байгуулсан. Эрүүл хооллолтын 2 төрлийн гарын авлага боловсруулан 174 иргэнд түгээсэн. Эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсанд 15 төрлийн постор, эрүүл зохистой хооллолт цуврал 4 видео бичлэгийг байршуулан иргэд олон нийтэд хүргэсэн. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-	90

						өөс албан хаагчдын хүүхдүүдэд сахарын хэрэглээнээс татгалзая, чихрийн хайрцагтай болж долоон хоногийн нэг өдрийг чихэртэй мөн чихэр идсэний дараа шүдээ тогтмол угааж байх талаар мэдээлэл, сургалт хийсэн. Эрүүл Монгол хүн, НЭМТ-өөс зарласан “САХАРГҮЙ 30 ХОНОГ CHALLENGE”-д нэгдэж аймгийн хэмжээнд “ДОЛОО ХОНОГИЙН НЭГ ӨДРИЙГ ЧИХЭРТЭЙ” арга хэмжээний удирдамжийг боловсруулан ЭМГ-ын даргын батлуулан ЭМБ-ууд, ЕБС-уудад хүргүүлж, “Сахарын хэрэглээнээс татгалзая”, “Сахарын хэрэглээ” зэрэг 7 төрлийн постор, 3 төрлийн видео бичлэгийг хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар Булган аймгийн ЕБС-ийн 1-р ангийн 1058 суралцагчид нүд, шүд, зүрх гэсэн 3 төрлөөр үзлэгийн үеэр эрүүл хооллолт, чихрийн хэрэглээний талаар мэдээлэл өгч 700 гаруй сурталчилгааны материал тараасан.	
1.3.3	Эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээний талаархи иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх.	Улсын төсөв	Сургалтын тоо Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо	• Сургалтын тоо - 5 • Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо - 2500 • Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо 48	• Сургалтын тоо- 8 • Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо- 3000 • Цахим орчинд байршуулах мэдээллийн тоо 52	“Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” сэдэвт өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд Электрон тамхины хор уршиг, Өсвөр үеийнхний эрүүл мэнд сэдвүүдээр сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн арга зүйч нар харьяа сургуулийн өсвөр үеийн сурагч нарт сургалт, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 1070 сурагчдыг хамруулж, 2000 гаруй тараах материал бүхий зөвлөмжийг түгээсэн.	90

						Эх үрсийн баярын үйл ажиллагааны үер эрүүл мэндийн боловсрол олгох өртөөнд архи тамхины хор уршгийн талаар 50 гаруй хүүхэд багачуудад мэдээлэл өгч 70 ширхэг гарын авлга брошур тараасан. Жил бүрийн тавдугаар сарын 31-нийг "Дэлхийн тамхигүй өдөр" болгон тэмдэглэж, дэлхий даяар тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралт, хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг. Энэ жил "Тамхины үнэнг илчилъе" уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж, үйлчилгээний газруудыг тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулахгүй байх санаачилга, уриалгыг хүргүүлсэн. Булган сумын өсвөр үеийн хүүхдүүдэд Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг, “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-тэй хамтран үзлэг, сургалт, сурталчилгааг зохион байгуулж нийт 100 гаруй сурагчдад мэдээлэл өгч гарын авлага тараасан.	
1.4	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.4.1	Нас, сэтгэхүйн онцлогт тохирсон контент, мэдээллийг бэлтгэн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг цахимаар түгээн дэлгэрүүлэх.	10,0	Телевизийн ярилцлага, нэвтрүүлэг, контент, сурталчилгааны тоо	Телевизийн ярилцлага- 2, нэвтрүүлэг- 4, контент-3, сурталчилгаа-10 удаа	Телевизийн ярилцлага- 4 , нэвтрүүлэг- 6, контент-5 сурталчилгаа-14 удаа	ЭМЯ, НЭМҮТ-ийн бэлтгэсэн 13 контентийг Сайхан Монгол тв-тэй хамтран тэгш цагуудад ТВ- ээр иргэд олон нийтэд хүргэн ажиллаж байна. Мөн “Анхдагч зөвлөгөө” иргэдийн эрүүл мэндийн боловсролд зориулсан ажил мэргэжил сурталчилсан 3 удаагийн нэвтрүүлэг, ярилцлага-4, контент-3, цахим сурталчилгааг-6 удаа бэлтгэн иргэдэд хүргэсэн. Үүнд:	100

						-Хүний папиллома вирусын халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх контент -11-14 настай хүүхдүүд болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт дархлаажуулалтын контент -ЕБС-ийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэг илрүүлэх эрт илрүүлэг үзлэгийг ярилцлага -Дархлаажуулалт- Ирээдүйн хамгаалалт” товллын дархлаажуулалтын ач холбогдол ярилцлага -24/3 шүдээ зөв угаах контент -Хүний папиллома вирусийн халдвараас сэргийлэх дархлаажуулалт ярилцлага -Амьсгалын замын халдварт өвчнөөс /Улаанбурхан, контент -Гар хөл амны өвчин, Менингит, Салхинцэцэг/ урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.gov.mn болон Булган Эрүүл мэндийн газар нүүр хуудсаар мэдээллийг хүргэн цахим хуудсаар мэдээ, мэдээллийг үнэн зөв хүргэх зорилгоор ЭМБ-д давхардсан тоогоор 212 мэдээллийг цахим хуудсан байршуулж, 42684 хүн цахим хуудсанд хандсан.	
1.4.2	Хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол зэрэг анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны хамрах хүрээг нэмэгдүүлэх.	10,0	Хамрагдсан хүн амын тоо	14000	15000	Аймгийн Засаг даргын А/32 тоот захирамжаар “Архи тамхи-Шинэ үеийн сонголт биш” нэрэмжит сарын аяныг жил бүрийн 3-р сард Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшээд байна. ЕБС-ийн 8-11-р ангийн 246 сурагчдад тамхи Тамхины үнэнийг	90

						илчилъё, амттаны цаана хор сэдвээр сургалт, мэдээллийг зохион байгуулж 2 төрлийн санамжийг 432 ширхгийг хэвлэн тараасан. Булган Эрүүл мэндийн газар нүүр цахим хуудсаар хорт зуршил, Буруу хооллолт, Хөдөлгөөний хомсдол таргалалт, халдвар, стресс зэрэг шалтгаан зэрэг сэдвээр 6 төрлийн зөвлөмжит мэдээллийг давхардсан тоогоор 23 удаа цахим хуудсан байршуулж, 12365 иргэн цахим хуудсанд хандсан. “Архи тамхи шинэ үеийн сонголт биш” уриан дор зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 4 төрлийн постер бэлтгэн цахим хэлбэрээр хүргэсэн. "Дасгал хөдөлгөөн цаг гаргая", аяныг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.	
1.4.3	Ундны ус, сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах.	20,0	Өрхийн тоо	0	4000	Иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүний чанарыг хадгалах зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар 2 төрлийн постер байршуулж иргэд олон нийтэд сурталчилан ажилласан. Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 эм ханган, 7 эмийн санд “Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль”, ЭМС-ын А/400 дугаар тушаал “Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам	90

						батлах тухай” журамын хэрэгжилтэд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгх ажлыг зохион байгуулж, дэмжлэгт хяналтын дагуу зөвлөмж хүргүүлсэн. Жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд нялхсын болон хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хоол, нялх, балчир хүүхдийн эмчилгээний тусгай сүүн тэжээл, нялх, балчир хүүхдийн ундаа, хооллох хэрэгсэлийг авах үед чанар, аюулгүй байдал, сав, баглаа боодол, шошгололт, хадгалалт, тээвэрлэлтийн байдалд анхаач худалдах авах талаар мэдээллийг 150 гаруй ээж нарт өгсөн.	
1.4.4	Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөө, эрсдлээс сэргийлэх сургалт нөлөөлийн ажлыг зохион байгуулах.	-	Сургалтын тоо	Зохион байгуулсан сургалтын тоо - 2	4	Баян-агт, Бугат, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хялганат , Орхон, Бүрэгхангай, Дашинчилэн, Баяннуур, Могод, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумын эрүүл мэндийн төв, 13 сумын 32 эмийн санд эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал, MNS 5260:2015, MNS 7376:2016 үнэлгээ хийж зөвлөн туслаж ажиллалаа. Мөн “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 6.1-д зааснаар эмийн жорын хяналтыг сайжруулах, жор бичилтийг бүртгэх, жорын дагуу эм худалдан авах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Эмийн жор цахимаар бичих, олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж 78 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Хишиг-Өндөр ,Рашаант сумын эрүүл мэндийн төвүүд сургалт зохион	90

						байгуулж Иргэдэд: • Танхимаар 7 удаа- 561хүнд • Цахимаар-203 хүнд • Хэвтэн эмчлүүлэгчдэд-803 • Постер-7 • Рийл-3 • Видео-2 • Тараах материал- 1005 хүн хамруулсан байна.	
1.4.5	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, үе тэнгийн зөвлөгчдийг чадавхижуулж, бэлтгэх.	10,0	Сургалтын тоо Хамрагдсан ОНЭМА, үе тэнгийн зөвлөгчийн тоо	Сургалтын тоо-1 ОНЭМА- 70 Үе тэнгийн зөвлөгч - 0	Сургалтын тоо-2 ОНЭМА- 140 Үе тэнгийн зөвлөгч - 20	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах нь” сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, хамтран цахимаар зохион байгуулан, сургалтад 16 сум, ӨЭМТ-ийн 26 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. Өсвөр үеийн хүүхдүүдэд эрүүл мэндийн зөв дадлыг бий болгох, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор үе тэнгийн сургагч нарыг бэлтгэж байна. Одоогийн байдлаар 60 үе тэнгийн сургагч бэлтгэгдсэн байна. 24/3-Шүдээ зөв угаа-2025 аныг хүрээнд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдүүлэх сургалтыг 21 сургуульд зохион байгуулж, нийт 1117 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан. Эцэг эхчүүдийн 80%-аас дээш хувь нь хүүхдийнхээ шүд угаалтын хяналт, дэмжлэгт анхаарч эхэлсэн. Үе тэнгийн нөлөөллөөр хүүхдүүд шүд угаалтын зөв дадалд хэвшсэн ба “шүд угаах тэмцээн” зэрэг сургуулийн дотоод санаачлага өрнүүлсэн 6 сургууль байна.	90
1.4.6	Ерөнхий боловсролын сургуульд "Шүд угаах	15,0	Шүдээ угааж хэвшсэн ангийн тоо	53	73	Аймгийн хэмжээнд 2024 оноос ЕБС-ийн бага ангийн суралцагсад	90

	цаг" бий болгон хэвшүүлж, амны хөндийн эрүүл ахуй сахих сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах.					үдийн цайны дараа шүд угаах цагийг бий болгож, шүдээ угааж эхэлсэн. “Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг Сайхан Монгол тв-тэй хамтран бэлтгэж цахим сургалтыг ЭМБ-ын дарга, нийгмийн ажилтан, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан. ЕБС-ын үдийн цай хөтөлбөрийн дараа шүд угаах цагийг 55 ангид бий болгосон. 24/3-Шүдээ зөв угаа-2025 аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 6470 хүүхдийг хамруулж, 3449 хүүхдэд нэмэлт эрдэсжүүлэлт хийсэн. Аяны турш амны хөндийн эрүүл мэндийн талаарх зөвлөмжит видео контент 3, зөвлөмж мэдээлэл 5 төрлийг бэлтгэн Эрүүл мэндийн газар болон бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар мэдээлж, нийгмийн сүлжээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд түгээсэн. Мөн аймгийн шүдний эмч мэргэжилтний холбооноос “Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох” мэдээллийг бэлтгэн аймгийн хэмжээнд нэгдсэн нэг сургалтын гарын авлагаар сургалт мэдээллийг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 35 удаагийн сургалт зохион багуулж, 3100 гаруй иргэдийг хамруулсан.	
1.4.7	Аймгийн Засаг даргын нэрэмжит зүрх судас, хоол боловсруулах,	60,0	Үзлэг зохион байгуулсан сумдын тоо	Нарийн мэргэжлийн эмч нарын	16 сум, 1 тосгонд	Аймгийн ЗД-ын нэрэмжит нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг Баян-Агт, Баяннуур, Бугат,	70

	хавдрын чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг сум, багийн түвшинд зохион байгуулах			үзлэгийг 9 сум, 1 тосгонд зохион байгуулсан.	Дашинчилэн, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг сумдад ажиллаж 1904 иргэнд дотор, мэдрэл, сүрьеэ, эмэгтэйчүүд, амны хөндий болон халдвартын эмчийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Үзлэгт хамрагдсан иргэдийн 66.5%-ийг рентген шинжилгээ, элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 2100 иргэн, сайн дурын дархлаажуулалт 1,2,3-р тунд 2011 хүн тун вакцин зарцуулсан байна. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоогоор дээд шатны эмнэлэгт 18 хүн илгээж, 25 хүнд шүдний эмчилгээ хийж, 4 иргэнийг АНэмнэлэгт хэвтүүлэн эмчилж, эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтад 8910 хүнийг хамруулан, 356 иргэнд эрүүл мэндээ хамгаалах, зөв дадал хэвшлийн зөвлөгөө өгч ажилласан байна. Сум, тосгон, өрхийн ЭМТ-үүд 17507 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг хамруулан, эрүүл мэндийн зөвлөгөө өгч ажиллалаа.		
1.4.8	Сүрьеэ, БЗДХ/ХДХВ өвчнийг эрт илрүүлэх үзлэг зохион байгуулж, илэрсэн өвчлөлийг эмчлэн эдгэрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	5,0	Илрүүлэгт хамрагдсан иргэдийн тоо	Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэгт хамрагдсан тоо-601 БЗДХ/ХДХВ илрүүлгийн тоо- 3959	Сүрьеэ-610 БЗДХ/ХДХВ илрүүлгийн тоо- 4000	Сүрьеэ илрүүлэх үзлэг, оношилгоог Баяннуур, Дашинчилэн, Баян-Агт, Тэшиг, Хутаг, Сэлэнгэ, Бугат, Хангал, Хялганат тосгонд зохион байгуулан 1057 хүнийг хамруулаа. Үзлэгт хамрагдсан иргэдийн 80%-ийг рентген шилжилгээнд хамруулан, 79 иргэний гэрт очиж айлаас айлд тусламж үйлчилгээг үзүүллээ. Эрт илрүүлэг үзлэгээр 4 өвчлөл шинээр илрүүлэн, эмчилгээнд хамруусан. 2025 оны эхний 5 сарын байдлаар БЗДХ-ын тохиолдол өмнө оны мөн үетэй харьцуулахад 7 тохиолдлоор буурсан байна. Эрүүл мэндийн	100

						байгууллагууд БЗДХ, ДОХ/ХДХВ илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлж хэвтэн эмчлүүлэгчид, жирэмсэн, сайн дураараа шинжилгээ өгч буй иргэд, нийт 2836 иргэнийг шинжилгээнд 13 өвчлөл илрүүлэн, эмчлэн эдгэрүүлсэн байна.	
1.4.9	Эрүүл мэндийн байгууллагуудын шүдний кабинетийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шүдний цоорлыг бүрэн эмчлэн эрүүлжүүлэх	45,0	Байгуулсан шүдний кабинетийн тоо	Баян-агт, Сайхан, Хутаг-өндөр, Хишиг-өндөр сумын эрүүл мэндийн төвүүдэд кабинетийн үйл ажиллагааг тогтмолжсон.	Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн сумын ЭМТ	Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвд шүдний кабинетийн үйл ажилагаа тогтмолжсон. Хялганат тосгоны эмнэлэгт кабинетийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70
			Шүд нь бүрэн эрүүлжсэн хүүхдийн тоо	5100	5680	ЭМС, БС-ын хамтарсан 2024 А/413, А/151 дугаар тушаалаар хийгдэж байгаа ЕБС-ын 1-р ангийн суралцагсдад хийхдээ амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт аймгийн хэмжээний 1056 хүүхдийг хамруулж, өнөөдрийн байдлаар эмчлэн эрүүлжүүлэлт 60%-тай явагдаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетаар урьдчилан сэргийлэх үзлэг зөвлөгөө мэдээллийг 13246 хүнд үзүүлж, 10011 хүнийг эмчилгээнд хамруулсан байна. Гурванбулаг, Тэшиг Мишээл сантай хамтран зохион байгуулсан үзлэгт 1-18 насны 1381 хүүхдийг хамруулж, 2999 шүдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Тус үзлэгээр 1-18 настай хүүхдийн дундах цоорлын эмчим буюу ЦЛАШ индекс 4,2 байгаа боловч 1-5 насны шүүн шүдэнд 6,4, 12-17 насны байнгын шүдэнд 4,8 буюу цоорлын эрчим хамгийн өндөр	

						байна.	
1.4.10	ЭМБ-уудад оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, иргэдийн чирэгдлийг багасгах		Дэвшилтэт технологийн тоо	3	7	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лаборатори, Чих хамар хоолойн тасагт оношилгоо, эмчилгээний арга технологийн нэр төрлийг нэмэгдүүлж цусанд тодорхойлох эрдсийн шинжилгээнд фосфор үзэх шинжилгээ, “Ринопластик” мэс заслын үйл ажиллагааг нэвтрүүлсэн. Мөн хүний папиллома вирусын халдварыг илрүүлэх шинжилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Мобайл тоног төхөөрөмж ашиглан алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хавдрын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг хангаж, 18 төрлийн химийн тариа худалдан авах гэрээ байгууллаа.	90
1.4.11	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг “CERVICARI AI” аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамруулах	15,0	Хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	1200	1400	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар “CERVICARI AI” аппаратын умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт нийт 431 эмэгтэйчүүдийг хамруулсан. Үүнээс хэвийн 313, эд, эсийн шинжилгээ өгөх шаардлагатай 118 эмэгтэйчүүдийг илрүүлсэн. Эсийн шинжилгээнд-22, эдийн шинжилгээнд-6 хүнийг хамруулсан. Эдийн шинжилгээгээр хавдрын урьдал-2 эмэгтэй оношлогдож, Leer эмчилгээнд-1 эмэгтэй хамрагдсан. Сайхан сумын эрүүл мэндийн төв нь гэрээт эмч ажиллуулан зорилтот насны иргэдийг эсийн шинжилгээнд	90

						хамруулан ажиллаж байна. Үүнээс 12 эмэгтэйг когуляци, 6 эмэгтэйг PRP эмчилгээнд хамруулсан.	
1.4.12	Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар үйлчилгээг үе шаттай хийж гүйцэтгэх.	1055.0	Барилгын засвар үйлчилгээ хийгдсэн байгууллагын тоо-	3	Барилгын засвар үйлчилгээ хийгдсэн байгууллагын тоо-3	Орон нутгийн 2025 оны төсвийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Б блокийн 1 давхарын рентген, яаралтай түргэн тусламжийн хэсэг 350.0 сая төгрөг, Хангал сумын ЭМТ-ийн барилгын засвар 305.0 сая төгрөг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засвар 400.0 сая төгрөгийн барилгын засварын ажлууд тус тус батлагдсан. Хангал сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчээр “Соотон Чоно” ХХК шалгарч, барилгын засварын ажлын гүйцэтгэл 40%-тай, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер худалдан авалт үнэлгээний шатанд явж байгаа, үр дүн нийтлэгдээгүй. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Б блокийн хэсгийн барилгын засварын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад гомдол гарч, үнэлгээ хойшлогдсон.	70
1.4.13	Эрүүл мэндийн байгууллагуудын тусгай хэрэгцээт тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажлыг үе шаттай хийж гүйцэтгэх.	472.0	Инженерийн шугам сүлжээнд холбогдсон байгууллагын тоо-Суурилуулагдсан лифтний тоо	1	Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон барилгын тоо-3 Суурилуулагдсан лифтний тоо-2	Орон нутгийн 2025 оны төсвийн санхүүжилтаар Сайхан сумын ЭМТ-ийн 2 барилгыг ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил 68.0 сая төгрөг, Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 104.0 сая төгрөг, Булган сумын “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн дулаан, цэвэр усны шугмыг төвлөрсөн системд холбох ажил 300.0 сая төгрөг, 160 ортой	70

						Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн барилгад лифт угсарч суурилуулах ажил 400.0 сая төгрөг нийт 872.0 сая төгрөг батлагдсан. Сайхан сумын ЭМТ-ийн ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажлын гүйцэтгэгчээр “Тэнгэр Хишиг” ХХК шалгарч шугмын ажил 06 сарын 02-нд эхлэнэ. Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэгчээр “Барс Оргил” ХХК шалгарч зураг төсвийн дагуу 100% ажлаа гүйцэтгэж дууссан. “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн барилгыг төвлөрсөн инженерийн шугамд холбох ажлын тендер шалгаруулалт 2 дахь удаагаа зарлан тендер шалгаруулалт явагдаж байна. Нэгдсэн эмнэлгийн барилгуудад лифт суурилуулах ажлын гүйцэтгэгчээр “Оакс инженеринг” ХХК шалгарч угсралтын ажил 70%-тай явагдаж байна.	
1.4.14	Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын зураг, төсөв боловсруулж батлуулах.	20.0	Батлагдсан зураг төсвийн тоо-	0	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентгений өрөө, хүлээн авах эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын тасгийн барилгын их засварын зураг, төсөв батлагдсан байна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентгений хэсэг, яаралтай тусламж, хүлээн авах, гемодиализ, эрчимт эмчилгээний тасгийн барилгын засварын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “Аслаан” ХХК гүйцэтгэж дууссан. Тус эмнэлгийн моргийн барилгын засварын ажлын зураг төсөл боловсруулах албан даалгаврын саналыг ГХБХБГазарт хүргүүлж, мэргэжлийн байгууллагаар зураг төслийн ажлыг гүйцэтгүүлж байна.	70

1.4.15	Эрүүл мэндийн байгууллагуудыг түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах.	360.0	Парк шинэчлэлт хийгдсэн автомашины тоо-	Аймгийн Нэгдсэн эмнэлэг-2, сумдын Эрүүл мэндийн төвүүд 11 автомашинаар хангагдсан.	Гурванбулаг, Бүрэгхангай, Хутаг-өндөр, Орхон сумдын Эрүүл мэндийн байгууллагууд түргэн тусламжийн автомашинаар хангагдана.	Гурванбулаг, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Орхон сумдын эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашины саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. ЭМЯ-наас автомашины хангалтыг энэ оны 10 сард багтаан нийлүүлэхээр мэдэгдсэн. Хугацаа болоогүй.	-
1.4.16	Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтыг нэмэгдүүлэх.	160.0	Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтын хувь-	92.5	Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтыг 94%-д хүргэнэ.	Аймгийн эрүүл мэндийн салбарт 2025 оны эхний хагас жилийн байдлаар тоног төхөөрөмжийн стандарт хангалт 93.2%-д хүрсэн. Үүнд: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтаар 16 сумын эрүүл мэндийн төвд 8 нэр төрлийн 16 ш Мобайл технологийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар 17 сумын 18 эрүүл мэндийн байгууллагууд, Сайхан сумын ЭМТ-д 35.0 сая төгрөгийн ЭХО аппаратаар тус тус хангагдсан. Орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт гемодиализын 2ш аппарат, шүдний тоног төхөөрөмж 1ш, Гурванбулаг сумын ЭМТ-д шүдний бор машин 1ш тус тус хангагдсан.	90
1.4.17	"Эрүүл Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	150,0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	70%	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2025 оны VI/32 дугаар тогтоолоор "Эрүүл Булган" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. "Эрүүл Булган" хөтөлбөрт 4 зорилтын 47 арга хэмжээг	90

						төлөвлөсөн. Шүд арга хэмжээний хүрээнд "Шүд угаалтын аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулан, 21 сургуулийн 144 хүүхэд оролцсон. Сургалтаар эцэг эх, сурагчид, багш нарын амны хөндийн эрүүл мэндийг сахих, хамгаалах мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 2807 хүнийг хамруулж, өссөн дүнгээр эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих иргэдийн 47,4%-ийг хамруулж, өмнөх оныхоос 4.2%-иар өссөн байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар 58 хорт хавдар өвчин оношлогдсны 21 буюу 36,2%-ийг эрт, 37 буюу 46,5%-ийг хожуу үед нь оношилж эмчилгээнд хамруулсан. Хожуу үеийн оношилгоо өмнө оноос 3,1%-иар буурсан байна. Хорт хавдар өвчнөөс сэргийлэх хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх 1 сарын аяныг зохион байгуулан, 16 сум, 1 тосгоны 19 ЕБС-ийн багш, 6-р ангийн суралцагчид, тэдний эцэг эхчүүд, асран харгалзагч нарын 1690 хүнийг сургалтад хамруулан, 263 хүүхдийг нөхөн дархлаажуулж, хамралт 22.4%-иар нэмэгдэж, хамрагдвал зохих хүүхдийг 63.1%-ийг хамрууллаа. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, зөв дадал эзэмшүүлэх, хандага өөрчлөх сургалт, сурталчилгааг тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулан 8910 хүнийг хамруулсан. Аймгийн НЭ, сум,	
--	--	--	--	--	--	---	--

						өрхийн ЭМТ-үүд амбулаторийн үзлэгт 8899, хэвтэн эмчлүүлсэн 3822, урьдчилан сэргийлэх үзлэгт 17507, сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалтад 3017, насанд хүрэгсдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 2807, нийт 33245 иргэнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 9068 иргэнтэй эргэх холбоотой ажилласан байна. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх 212 сурталчилгаа, мэдээллийг цахим хуудсан байршуулж, цахим орчноос 42684 хүн мэдээлэл авч үзсэн байна. Аймгийн хэмжээнд 31-с дээш насны иргэдийн дунд элэгний В, С вирус илрүүлэх үзлэг, шинжилгээнд 2100 хүнийг хамруулж, В вирусгүй иргэдийг сайн дурын дархлаажуулалтад хамруулан ажиллаж байна. Хутаг-Өндөр, Сайхан сумдын засаг дарга нар иргэдээ сайн дурын дархлаажуулалтад хамруулах ажилд 2-3сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.	
1.4.18	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	-	Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	2021-2024 онд нийт 46 эмнэлгийн мэргэжилтэн	58	Төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн 2025-2026 сургалтад 6 их эмч 4 сувилагч тусгай мэргэжилтэн нийт 10 мэргэжилтэн хамрагдсан. Төвлөрлийг сааруулан нарийн мэргэшлийн тусламж үйлчилгээг орон нутагт үзүүлэх ажлын хүрээнд ХӨСҮТ-тэй хамтран хавдарын хими эмчилгээний их эмч, хавдрын эмчилгээний эм найруулагч, сувилагч бэлтгэх богино хугацааны сургалтад 3	90

						мэргэжилтнийг хамруулж байна.	
1.4.19	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг багаар нь өндөр хөгжилтэй оронд урт болон богино хэмжээний сургалтад хамруулж, туршлага судлуулах	130,0	Сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо-	2021-2024 онд нийт 19 эмнэлгийн мэргэжилтэн	26	БНХАУ-д Сэргээн засах чиглэлээр 1 их эмч, БНСУ-д туршлага солилцох арга хэмжээнд 1, анхан шатны тусламжийн чиглэлээр 9 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Тайвань улсад Чих хамар хоолойн чиглэлээр 1, БНЭУ-д Нүдний чиглэлээр 1 нийт 13 ажилтныг байрны дадлага сургалт, туршлага солилцох сургалтад хамрууллаа.	90
1.4.20	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон нутгийн дэмжлэг урамшуулал үзүүлэх	70,0	Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа	1	4	Эрүүл мэндийн байгууллагууд ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны таатай орчин бий болгох, эмнэлгийн мэргэжилтнүүдийг амьдрах байраар хангахад дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх зэргээр албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.	90
			Эрүүл мэндийн салбарын албан хаагч	10	20	-Гадаад улсад мэргэжлийн сургалтад хамрагдсан, туршлага судлах үйл ажиллагаанд оролцсон 6 албан хаагчид дэмжлэг үзүүлсэн. -Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан 4 ажилтанд дэмжлэг үзүүлсэн. -сумдад баригдсан төрийн албан хаагчийн орон сууцанд 3, эмнэлгийн хуучин барилгад 13, түүрээсийн байранд 1 эмнэлгийн мэргэжилтэн амьдарч байна. -Дашинчилэн суманд 2 айлын зөөврийн сууц шинээр ашиглалтад оруулсан. -1 байгууллага сувилахуйн пост, эх баригчийн өрөө, гадна доторх гэрэлтүүлэг зэргийг шинээр засварлаж ажиллах орчноо	

						сайжруулсан байна. -Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 309, умайн хүзүүний эрт илрүүлэгт 44, хөхний өмөнгийн эрт илрүүлэг шинжилгээнд 66 албан хаагч хамрагдаж, 1 албан хаагч хөхний момографикийн шинжилгээнд хамруулсан. В,С илрүүлэх шинжилгээ, дархлаа тогтоцын шинжилгээнд 254 ажилтан хамрагдаж, 127 албан хаагч В гепатитын сайн дурын сэргээх тун, бүрэн тун авах дархлаажуулалтад хамрагдсан.	
			Зарцуулсан хөрөнгө	7,3	40	-Гадаад сургалт, туршлага солилцох сургалтад хамрагдсан 6 ажилтанд 8.3 сая, дотоодын сургалтад хамрагдсан 4 ажилтанд 929.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. -1 их эмчийн байрны түрээсийн зардалд 900.0 мянга, 3 ажилтны амьдрах байрны дулаан, цахилгааны зардалд 3.1 сая төгрөг зарцуулсан. -АНЭ, Рашаант, Хялганат тосгоны ЭМТ-ийн 255 ажилтанд 326.8 сая төгрөгийн 1 сарын үндсэн цалин олгов.	
1.5	Салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.5.1	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх.		Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн хувь-94	Хэрэгжилтийн хувь 96	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2025 оны ажлын төлөвлөгөөг 8 зорилт 60 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. төлөвлөгөөний хэрэгжилт 90%. Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 04 сард 10 төрлийн 84 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 10,000 хүн амд 14,0 промилль байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс	90

